



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/346

Ховд

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн /А/ заалт, Малын генетик нөөцийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох ажлыг орон нутагт зохион байгуулах үүрэг бүхий мэргэшсэн шинжээчийн дэд ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Гончигсүрэн - Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Гишүүд: Ц.Пүрэвсүрэн – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

С.Шүрхүү -Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны мэргэжилтэн

Д.Нямсүрэн -Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны мэргэжилтэн

Б.Атарсайхан -Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны мэргэжилтэн

Ж.Болормаа - Хүнс, хөдөө аж ахуйн газрын нягтлан бодогч

Нарийн бичгийн дарга:

Г.Бат-Өлзий - Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга

2. Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлсон ажлын үр дүнг тайлагнаж аймгийн Засаг даргын зөвлөлд тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Г.Гончигсүрэн/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



02 01720  
D/Zax-A/346-Da